



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/429

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.4 дэх заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дах заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт /Петровис ШТС-ын баруун талд/ байршилтай иргэн Доржсүрэн овогтой Багаболд /ЗЮ:85040639/-ын үйлчилгээний зориулалттай 400 м.кв /0,04 га/ газрыг Цэдэндорж овогтой Батзаяа /ЗЮ:79012066/-д зориулалтаар нь шилжүүлж 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/429 тоот захирамжийн иргэн Д.Багаболдод холбогдох хэсэг мөн газар эзэмших 000575013 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200355